

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ, ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР  
НУТГИЙН ТУХАЙ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ, АШИГТ МАЛТМАЛЫН  
ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБОГДУУЛАН  
ИРҮҮЛСЭН ИРГЭДИЙН ӨРГӨДЛИЙН ДАГУУ ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТАЙЛАН**

**Нэг. Өргөдлийн байнгын хороонд ирүүлсэн иргэдийн өргөдлийн агуулга**

УИХ-ын Өргөдлийн байнгын хороонд Байгаль орчныг хамгаалах тухай, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, соёлын өвийг хамгаалах тухай, ашигт малтмалын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилттэй холбогдуулан иргэдээс дараах өргөдлүүдийг ирүүлсэн байна. Үүнд:

1. Дорноговь аймгийн Айраг сумын 7 иргэнээс өргөдөл ирүүлж, Айраг сумын нутагт орших Цагаан дэлийн агуйн орчимд аж ахуйн нэгж, иргэд ашигт малтмалын /жонш/ олборлолтын үйл ажиллагаа явуулахдаа агуйн амыг дэлбэлж түүх, соёлын дурсгалт газрын байгалийн унаган тогтоцыг алдагдуулсан, тухайн орчны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанаас их хэмжээний тэсэлгээний дуу чимээ, тоос шороо үүсч байгаа нь хүн, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа төдийгүй ундны усны хомсдол үүсгэж эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг алдагдуулж байгаа тул шалгаж, буруутай этгээдүүдэд хариуцлага тооцон, учирсан гэм хорыг арилгуулах арга хэмжээ өвч өгөх;

2. Хөвсгөл сумын 19 иргэнээс Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошууны эрхэм сүлд тахилга бүхий онгон дархан шүтээн сахиус болж гурван жилд уг хошууныхан нэг удаа тахидаг байсныг одоогоор Хөвсгөл, Хатанбулаг сумдын иргэд уламжлал болгон тахин шүтэж байгаа Хутаг уулыг дэрлэн уул уурхайн компани ажиллах болсныг зогсоож, ховор ан амьтан, ус булаг, шандууд нь устаж, үгүй болох аюулд өртөөд байгаа тул байгаль, түүхийн дурсгалт газрыг цогцоор нь улсын тусгай хамгаалалтад авах, эртнээс хил манаж ирсэн малчдын бэлчээр ус, тахилгын өв соёлыг хадгалж авч үлдэх, хамгаалах талаар арга хэмжээ авах;

3. Дэлгэрэх сумын 5 иргэнээс нутгийн тахилгат хайрхан болох “Чандмань хар” хэмээх /цувран тогтсон толгодыг оролцуулан Ноён, Хатан, Хүү, Бэр толгой гэж домоглон нэрлэдэг/ уулын орой “Алтан овоо”-г ашиглаж /төмөр/ эхэлснээс хойш хүн, малын өвчин их гарч, хуурайшин тоосжилт ихсэж, малын бэлчээр, ус хомсдож байгаа, уулын баруун урд энгэрийн шар бууц хэмээх газарт гар аргаар алт олборлож, нутгийн иргэдийн шүтлэгтэй хайрханыг сүйтгэж байгаа үйл ажиллагааг зогсоож, улсын тусгай хамгаалалтад авч нөхөн сэргээх;

4. Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын 23 иргэнээс тус сумын Хүслэнтэйн аман гол хэмээх газар нь БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Эпитот” ХХК-ийн нүүрсний ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд хамаарагдсан. Аймгийн тусгай хэрэгцээний газарт хамаарах хэсгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 сарын 02-ны

өдрийн хурлын 128 тоот тогтоолоор тусгай хэрэгцээнээс гарган “Эпитот” ХХК-д ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгосон. Уг газрыг ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр ашиглуулах эсэх асуудлаар тус сумын иргэдээс авсан санал асуулгад 637 хүн оролцсоноос 533 иргэн буюу 83.7 хувь нь эсрэг санал өгсөөр байхад дээрх шийдвэр гаргасанд иргэд гомдолтой байна. “Эпитот” ХХК нь хүрэн нүүрс олборлон цахилгаан болон дулааны станц байгуулах төсөл хэрэгжүүлнэ гэж байгааг иргэд үндэслэлгүй бөгөөд рашаан ус ширгэх, байгалийн тэнцвэр алдагдаж, малчид нутаглах бэлчээргүй болох, шүтлэгт уул хайрхан сүйтгэгдэх эрсдэлд ороод байна. Иймд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалж, малчдын амгалан тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх зэрэг өргөдлийг тус тус ирүүлсэн байна.

Өргөдлийн байнгын хорооны гишүүдийн ажиллах чиг үүргийн хуваарь, өргөдөл шийдвэрлэх журмын дагуу дээрх өргөдлүүдийг шийдвэрлүүлэхээр Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, С.Ганбаатар, О.Содбилэг нарт хуваарилсаны дагуу хуулийн хэрэгжилтийн хяналт шалгалтын ажил хийлээ.

Дээрх өргөдлүүдийг судлах хүрээнд Өргөдлийн байнгын хорооны ажлын албанаас 2014 оны 10 дугаар сарын 03-наас 06, 11 дүгээр сарын 12-ноос 16-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Айраг, Хөвсгөл, Дэлгэрэх сумдад Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Шинжлэх ухааны академийн холбогдох хүрээлэнгүүд, “Монголын агуй судлалын холбоо” ТББ, “Монголын тахилгат газар нутгийн судалгаа, мэдээллийн төв” ТББ-ыг оролцуулсан хяналт шалгалт зохион байгууллаа. Мөн 2014 оны 11 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн Баян-Өндөр суманд ажиллан иргэдийн өргөдлийн дагуу нөхцөл байдалтай газар дээр нь танилцав.

Улмаар 2014 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр орон нутагт ажиллсан ажлын үр дүнгээр “Дорноговь аймгийн Цагаан дэлийн агуй, Хутаг уул, Чандмань хар уулын бүс нутаг дахь Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Хэлэлцүүлгээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, нөхөн сэргээлт, түүнд тавих хяналт, байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилт /БОНХЯ/, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт ба орон нутгийн иргэдийн эрх ашиг, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт /АМГ/, Ашигт малтмалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, түүнд тавих хяналт /МХЕГ/, Хутаг уул, түүний Монголын түүхийн холбогдол /ШУА-ын Түүхийн хүрээлэн/, Говийн /Хутаг уул/ биологийн төрөл зүйл /ШУА-ын Биологийн хүрээлэн/, Уул хайрхадыг дархлан шүтэж ирсэн уламжлал, соёл түүний ач холбогдол /Монголын тахилгат газар нутгийн судалгаа, мэдээллийн төв/ зэрэг сэдвээр мэдээлэл хийлгэж, оролцогчдын саналыг сонслоо.

### **Хоёр. Өргөдлийг судалсан тухай**

***Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших Цагаан дэлийн агуйн***

***талаар ирүүлсэн өргөдлийг судалсан тухай:***

Монгол улсын хамгийн том урт агуй бөгөөд газрын доорх байгалийн үзэсгэлэнт байдал, тогтоцын хувьд дахин давтагдашгүй, дотроо 2 нуур, мөсөн танхим, амьтны үлдэгдэл яс, ховор нандин агуйн бүрдэлтэй<sup>1</sup>.

*Агуйн бүс нутгийг тусгай хамгаалалтад авсан байдал:*

- 2011 онд агуйн амыг тойрсон 3.63 га газрыг Дорноговь аймгийн ИТХ-ын тогтоолоор аймгийн тусгай хамгаалалтад;
- 2013 онд дээрх 3.63 га газрыг оролцуулан 116 га газрыг Айраг сумын болон Дорноговь аймгийн ИТХ-ын тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан гэх боловч солбицлыг шалган үзэхэд өөр газрыг хамарч байна.

*Цагаан дэлийн агуйн бүс нутагт явуулсан ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа:*

- 1968 онд хайлуур жонш олборлож байсан;
- 2000-2004 онд “Таван баатар” ХХК;
- 2004-2006 онд “Эрдэс плазм” ХХК;
- 2007-2010 онд “Эжунмэн” ХХК /ашиглалт/ 116 га талбайд;
- Хууль бусаар жонш олборлогчид.

*Агуйн ойр орчимд 5 аж ахуйн нэгж ашиглалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр жонш олборлож байна. Үүнд:*

- “Дугуй уул” ХХК;
- “Эм Си Ти Ти” ХХК;
- “Таванбаатар” ХХК;
- “Мөнхболор хүрээ” ХХК;
- “Дунфанлунма” ХХК.

*Ашигт малтмал олборлохтой холбоотойгоор үүссэн хор уршиг:*

- Агуйн жоншийг эвдэж авснаас, нуранги үүсэж соёлын өвийг бүртгэхэд тавигдах шаардлагыг хангахгүй болсон<sup>2</sup>
- Ашиглалтын үйл ажиллагаанаас үүссэн тоос шороо, тэсэлгээний дуу чимээ, орчны эвдрэлээс хүн, мал амьдрах нөхцөл алдагдсан, тэдгээрийн эрүүл мэндэд

<sup>1</sup> Агуй судлаач Э.Авирмэдийн 2009 онд Оксфордын Их сургууль, ОХУ, Монголын судлаачидтай хамтран Цагаан дэлийн агуйд хийсэн судалгаа

<sup>2</sup> Түүх соёлын дурсгалт зүйлийн бүртгэлийн ажлын хэсгээс 2009 онд хийсэн үнэлгээ

сөргөөр нөлөөлж буй, мөн усны хомсдол үүссэн<sup>3</sup>.

***Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал:***

Цагаан дэлийн агуйн орчимд үйл ажиллагаа явуулж буй “Эм Си Ти Ти” ХХК, “Дунфанлунма” ХХК-ууд нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээр тавигдсан нөхцөл шаардлагыг биелүүлж ажиллаагүй, 2014 оны байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг БОНХЯ-аар батлуулсан боловч төлөвлөгөөнд заагдсан хөрс, ус, агаарын шинжилгээг тогтмол өгч сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.1, 9.3, 9.6 дахь заалтыг зөрчсөн, “Экилешия” ХХК нь Засгийн газрын 311 дугаар тогтоолын дагуу өөрийн дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлээгүй нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2 дахь заалтыг тус тус зөрчсөн хэмээн Мэргэжлийн хяналтын байцаагчийн хяналт шалгалтаар тогтоогдсон байна. Гэвч өмнө эдгээр зөрчлүүдэд Дорноговь аймгийн мэргэжлийн улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлсэн байгаа тул давхардуулан арга хэмжээ авах боломжгүй байгаа талаар хяналт шалгалтын танилцуулгад дурджээ. Иймд дээрх зөрчлүүдийг арилгах арга хэмжээ авсан эсэхийг нягтлах, зөрчлийг арилгаагүй тохиолдолд дараагийн шатны арга хэмжээг авах, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шаардлагатай байна.

***Дорноговь аймгийн Хатанбулаг, Хөвсгөл сумын нутагт орших Хутаг уулын талаар ирүүлсэн өргөдлийг судалсан тухай:***

Хутаг уул нь Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошууны үе дамжин шүтэж ирсэн тахилгат уул /Дорноговь аймгийн хамгийн өндөр цэг/ бөгөөд Эзэн Чингэс хааны их цагаан сүлдний сүүлчийн дагавар сүлдний нэг нь уг хайрханы хойд бэлд тахигдаж байсан ба Сүлдэнэ хөх толгойд залагдсан байна. Сүлдэнэ хөх толгой, Гуа тээг, Эргэлийн зоо, Ац богд, Хоёр загал, Баруун, зүүн хасар, Шивээ, Бурхант, Дарьт, Хатаны булаг зэрэг Чингэс хааны түүхтэй холбогдсон олон газар Хутаг уулын орчинд байх ба Говийн нэг, тавдугаар ноён хутагтуудын төрсөн болон нутаглаж, тахин шүтэж байсан дагшин газрууд юм. Энэ уул нь Бурхант, Их, Бага, Дунд Буурал болон Хуцын хүрэн, Эрээн нуруу хүртэл үргэлжилдэг. Хутаг ууланд зэрлэг сонгино, агь, борхой, таана хөмүүл, чулуун таваг, алтан харгана, алтан утас, чихэр өвс, тэмээн хөх хар өвс зэрэг 100 гаруй төрлийн өвс ургамал, аргаль, хулан, хар сүүлт зээр, цагаан зээр, чоно, үнэг, хярс, мануул дорго, морин шилүүс зэрэг 10 гаруй төрлийн ан амьтан, хөх цахлай, ууль, ятуу, ногтруу, тас зэрэг 30 гаруй жигүүртэн шувууд нутагладаг говийн байгалийн унаган төрхийг хадгалсан газар юм<sup>4</sup>.

***Хутаг уулын орчимд байгаа түүх, соёлын өвийн талаар:***

- 2009 онд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн шалгалтын явцад Хутаг уулын ойр орчим болон уулнаас нийт 9 түүх соёлын үл

<sup>3</sup> Орон нутгийн иргэдийн өргөдөл

<sup>4</sup> Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын танилцуулга

хөдлөх дурсгал болох булш хиргисүүр, бүлэг, зэл чулуу, хийдийн туурийг бүртгэсэн байна. Хутаг уулын ойр орчимд эрт дээр үеийн чулуужсан том жижиг мөр, адууны, нохой, хүний мөр, эртний булш, хиргисүүр, хадны сүг зураг зэрэг түүх соёлын үл хөдлөх дурсгалууд олноор илэрсэн<sup>5</sup>.

- МЭӨ III- МЭ I зууны үед холбогдох хүннүгийн үеийн булш, оршуулгын дурсгал, хүрэл, төмрийн түрүү үед холбогдох 3 дурсгал, Монголын үед холбогдох булш, оршуулгын дурсгалтай ижил төстэй байж болох 13 дурсгал, МЭ VI-VIII зууны үед холбогдох түрэг угсаатны үлдээсэн зэл чулуун байгууламж 4, нийт чулуун байгууламж 43, оршуулгын дурсгал 54, зэл чулуу 4, сүм хийдийн туурь 1 зэрэг 102 дурсгалыг олж бүртгэсэн байна<sup>6</sup>.

*Хутаг уулын бүс нутгийг тусгай хамгаалалтад авсан талаар:*

- Хутаг уулыг байгалийн нөөц газрын ангиллаар аймгийн тусгай хамгаалалтад 1988.12.09-ний 99 дүгээр тогтоолоор 33725.46 га газрыг, 1999.12.30-ны өдрийн 5/05 дугаар тогтоолоор 500 га газрыг авсан гэх мэдээлэл байх боловч тусгай хамгаалалтад авсан тогтоол, шийдвэр олдохгүй байна/орон нутгийн архив болон Үндэсний төв архивт байхгүй/<sup>7</sup>.

*Хутаг уулын бүс нутагт явуулсан ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа:*

- 2004 оноос иргэн Б.Цогтсайхан;
- 2005 оноос иргэн Л.Ганбаяр;
- 2006 оноос “Занаду майнз монголиа” ХХК;
- 2007 оноос “Занадуметалс монголиа” ХХК;
- 2008 оноос “Хангихүдэр” ХХК;
- 2012 оноос “Галаксимаининг монголиа” ХХК /2013 онд зарим талбайг хэсэгчлэн цуцалсан/;
- 2014.10.15-нд “Галаксимаининг монголиа” ХХК-д ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон.

*Ашигт малтмал олборлохтой холбоотойгоор үүсэх хор уршиг:*

- Орон нутагт холбогдох түүх, уламжлалт зан үйл, тахилга, шүтлэгийн өв соёл устах;
- малын бэлчээр, усны эх, ховор ан амьтдын идээшиж, ундаалах, нүүдэллэх шилжилт хөдөлгөөний зам орсон нь тэдгээрийг дайжих, устаж үгүй болгох.

<sup>5</sup> Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын танилцуулга

<sup>6</sup> ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс “Галаксимаининг Монголиа” ХХК-ийн Хутаг уул нэртэй тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн тайлан

<sup>7</sup> Дорноговь аймгийн Засаг даргын 2008 оны албан бичиг, Үндэсний төв архиваас авсан лавлагаа

### ***Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал:***

1. Ашигт малтмалын газраас 2014.10.15-нд “Галаксимайнинг монголиа” ХХК-д ашиглалтын тусгай зөвшөөрлийг угсаатны зүйн судалгаа хийгээгүй /археологи, палентеологийн судалгаа хийсэн/ байхад олгосон нь Ашигт малтмалын тухай хуулийн 40<sup>1</sup>.2-д “Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, **угсаатны** мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, **ашиглахыг хориглоно**” гэж, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.8-д “... ашигт малтмалын хайгуул хийх, **ашиглах** зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палентеологи, археологи, **угсаатны** мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна” гэж тус тус заасныг зөрчиж байна.

2. Орон нутгаас 1980-1990 оны хооронд Хутаг уулыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан боловч нутгийн захиргааны байгууллагын хариуцлагагүй байдал, бичиг хэргийн хадгалалт, хамгаалалт муутай байдлаас тогтоол, шийдвэр алдагдсан, шийдвэрийг Ашигт малтмалын газарт бүртгүүлэх арга хэмжээ аваагүй, Дорноговь аймгийн засаг дарга /2004 онд/ орон нутгийн иргэдийн саналыг харгалзан үзэлгүйгээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох мэдэгдлийг дэмжиж санал өгсөн байна.

### ***Дорноговь аймгийн Чандмань хар уулын талаар ирүүлсэн өргөдлийг судалсан тухай:***

Чандмань хар уул нь Дэлгэрэх сумын нутагт орших бөгөөд уулынхаа урд энгэрээр бүлэг булшаар хүрээлэгдсэн, төмрийн хүдрийн агууламж өндөртэйгээс хар өнгөтэй харагдах уртрагийн дагуу 3 км орчим сунан тогтсон бэсрэг уулсаас бүрдэнэ. Тус бэсрэг толгодын ноён оргилыг “Чандмань хар” хэмээх агаад нутгийн иргэдийн жил бүр тахидаг.

#### ***Чандмань хар уулан дахь түүх, соёлын өвийн талаар:***

2004 онд ШУА-ын Археологийн хүрээлэнгээс “Айвенхоу майнз монголиа” компанийн хүсэлтээр малтлага хийхэд 300 орчим түүх, дурсгалын зүйлс илрүүлсэн. Судалгааны ажлын явцад 26 эртний булшийг авран хамгаалах малтлага хийж, эдгээр дурсгал нь Хүрэл зэвсгийн үеийн /МЭӨ II мянган жилээс МЭӨ VII зуун/ болон 12-13 дугаар зууны үед холбогдох түүх соёлын үл хөдлөх дурсгалууд байгааг тогтоосон.

2011 онд ШУТИС-ийн Түүх, соёл судлалын тэнхимийн судлаачид, 2012-2014 онд ШУА-ын хамгаалах секторын судлаачид “Засаг чандмань майнз” ХХК-ийн хүсэлтээр тус компанийн тусгай зөвшөөрөлтэй талбайд судалгаа хийж, уул уурхайн үйл ажиллагаа явуулахад өртөх эрсдэлтэй байсан 278 булш тахилын байгууламжийг малтан судалж, чөлөөлсөн байна.

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор Чандмань хар уулын орчмын булш, чулуун зэвсгийн болон үйлдвэрлэлийн ул мөр бүхий дурсгалт

газрыг аймаг нийслэлийн хамгаалалтанд байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтанд хамааруулан, Соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн байна. Өнөөдрийн байдлаар Чандмань хар уулын орчимд авран хамгаалах малтлага судалгаанд хамрагдаагүй 50 гаруй булш, тахилын газар үлдээд байна.<sup>8</sup>

*Чандмань хар уул орчмын газрыг тусгай хамгаалалтад авсан байдал:*

- 2012 оны 02 сарын 16-ны өдрийн Дэлгэрэх сумын ИТХ-ын 46 тоот тогтоолоор уулын ноён оргилоос 3 км радиус бүхий газрыг сумын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.

*Чандмань хар уулын бүс нутагт хийгдсэн ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа:*

- “Юниверсальминералз” ХХК /3647Х/;
- “Засаг чандмань” ХХК /MV015594/;
- “Засаг чандмань майнз” ХХК /ашиглалтын тусгай зөвшөөрлийг урьд эзэмшиж байсан хуулийн этгээдээс бүхэлд шилжүүлэн авсан/ ;
- “Засаг чандмань майнз” ХХК төмрийн хүдрийг олборлон хуурай аргаар баяжуулж байгаа бөгөөд “Сайншанд Аж Үйлдвэрийн Парк” төслийн хүрээнд төмрийн хүдрийг нойтон аргаар баяжуулах үйлдвэр байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байгаа.

*Ашигт малтмал олборлохтой холбоотойгоор үүсч болзошгүй хор уршиг:*

Чандмань хар уулын зүүн хормойгоор “Аман усны гол” байдаг бөгөөд энэ голыг дагаж 15 өрх айл амьдарч, малаа ундаалдаг. “Засаг чандмань майнз” ХХК нь төмрийн хүдэр нойтон аргаар баяжуулах үйлдвэр байгуулахтай холбоотойгоор гүний усны хайгуулын ажлыг хийж, үр дүнгийн тайланг Усны газрын Мэргэжлийн зөвлөлийн хурлаар батлуулсан байх ба үйлдвэрлэл явуулах явцад усны нөөцийн хомсдол үүсэх эрсдэлтэй. Иймд тус үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэх, усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах асуудлыг хамтад нь авч үзэх шаардлагатай.

Мөн Мэргэжлийн байгууллагын судалгаанд хамрагдаагүй үлдсэн 50 гаруй булш, тахилын газар хөндөгдөх, устаж үгүй болох нөхцөл байдалд байна.

***Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал:***

Дэлгэрэх сумын ИТХ 2014 оны 09 сарын 24-ны өдөр 6/02 тоот тогтоолоор “Сумын нутаг дэвсгэр дээр бичил уурхайг зохицуулах, иргэд хувиараа ашигт малтмал олборлох, зөвшөөрөл олгох” журмыг баталж, Чандмань уулын баруун урд хэсэгт “Шар модны бууц” гэх газарт нийт 15.2 га газарт бичил уурхайн хэлбэрээр алт олборлож байна.

<sup>8</sup> Соёл, спорт, аялал жуулчлалын яамны 2014 оны 10 сарын 23-ны өдрийн албан тоот бичиг

Бичил уурхайн үйл ажиллагааг Ашигт малтмалын тухай хууль, Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-аар зохицуулах бөгөөд дээрх үйл ажиллагаа нь дараах хууль тогтоомжийг зөрчиж байна. Үүнд:

1. Ашигт малтмалын газраас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлтийг гаргуулалгүйгээр газрыг бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргасан, улмаар олборлолт явуулсан нь Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13, 11.1.23-т заасныг зөрчсөн;
2. Дэлгэрэх сумын ИТХ-аас 2014 оны 09 дүгээр сарын 24-ний 6/02 дугаар тогтоолоор “Бичил уурхайг зохицуулах, иргэд хувиараа ашигт малтмал олборлоход хяналт тавих, зөвшөөрөл олгох журам”, “Бичил уурхайг зохицуулах сангийн журам”, “Ашигт малтмал олборлох тухай гэрээ”, “Ашигт малтмал олборлох нөхөрлөл, гишүүдэд олгох гэрчилгээний загвар”-ыг баталсан нь Ашигт малтмалын тухай хуулийн 3.2, Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолыг бүхэлд нь зөрчсөн;
3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээг Иргэний хуулийн 35, 36.4, 481.1-д заасны дагуу зохион байгуулагдсан нөхөрлөл, хоршоо байгуулаагүйгээр хураамж авсан нь Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.23, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 3.3, 3.4-т заасныг зөрчсөн;
4. Олборлолт хийгдсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн зардлыг тооцон зохих мөнгөн хөрөнгийг дундын санд төвлөрүүлэх ажил зохион байгуулаагүй нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 3.8-д заасныг зөрчсөн;
5. “Засаг чандмань майнз” ХХК нь ус ашиглах эрхийн бичиггүй байгаа нь Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11 дэх заалтыг зөрчсөн байна.

***Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших Аман голын талаар ирүүлсэн өргөдлийг судалсан тухай***

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутагт байрлах Аман гол нь Монгол Алтайн нурууны салбар болох Гичгэний нурууны зүүн өмнөд хэсэг, Халзан Бүрдийн нурууны зүүн хойд төгсгөл хэсгээр байрладаг ажээ. Орд бүхий газарт хэд хэдэн булаг шанд, гол горхи оршдог бөгөөд эмийн ургамалтай, аргаль, янгир зэрэг ховор ан амьтад нутагладаг байна. Мөн Буурал хайрхан, Буньдарийн овоо хэмээх тахилгат газартай. Баян-Өндөр сумын нэг, гурав, дөрөвдүгээр багийн малчид тэрхүү нутагт малаа бэлчээрлүүлдэг ба ган, зуд нүүрлэхэд тухайн газар оторлодог байна<sup>9</sup>.

*Аман голын бүс нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан байдал:*

<sup>9</sup> Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын иргэдийн өргөдлөөс



- Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2005 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 60 дугаар тогтоолоор нийтийн эдэлбэрийн газар, улс, аймгийн тусгай хамгаалалттай газар, ашигт малтмалын лицензтэй газраас бусад нутаг дэвсгэрийг бүхэлд нь тусгай хэрэгцээний газарт авчээ;
- Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 128 дугаар тогтоолоор Баян-Өндөр сумын нутагт орших “Аман гол” нэртэй газрын 6373.82 га талбайг аймгийн тусгай хэрэгцээний газраас чөлөөлжээ.

*Аман голын бүс нутаг дахь ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа:*

- Иргэн Н.Мөнхтөрд 2005 оны 8 сарын 26-ны өдөр 6535 га талбайд 10351Х тоот хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон;
- “Эпидот” ХХК-д 2007 оны 1 сарын 22-ны өдөр хайгуулын тусгай зөвшөөрлийг шилжүүлжээ;
- “Эпидот” ХХК-ийн хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн 6373.82 га-д 2014 оны 10 сарын 15-ны өдөр MV-17630 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон.

*Ашигт малтмал олборлохтой холбоотойгоор үүсэх хор уршиг:*

Ашиглалтын талбайн газар нь Баян-Өндөр сумын гол, усны сав газар бөгөөд ховор нандин эмийн ургамал ургаж, аргаль, янгир нутагладаг ба уул, уурхайн үйл ажиллагаанаас бэлчээр усгүй болох, тахилгат Буурал хайрхан, Буньдарийн овоо сүйдэх, ан амьтад дайжих эрсдэлтэй. Түүнчлэн ойр орчинд нутагладаг тус сумын нэг, гурав, дөрөвдүгээр багийн малчид ган, зуд нүүрлэхэд тухайн газар оторлодог байна<sup>10</sup>.

### ***Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал:***

1. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ... тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснийг үндэслэн газрыг аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг тогтоох ... бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заажээ. Эндээс үзэхэд газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэрийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргахаар заасан боловч Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор газрыг тусгай хэрэгцээнд авсан нь Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасныг зөрчсөн байна.
2. Аман гол орчмын газрыг 2005 оны 6 сарын 23-ны өдрийн шийдвэрээр орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан боловч уг газарт 2005 оны 8 сарын 26-ны өдөр

<sup>10</sup> Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын иргэдийн өргөдлөөс

ашигт малтмалын хайгуулын зөвшөөрлийг давхардуулан олгосон, улмаар 2014 онд ашиглалтын зөвшөөрөл хүсэх хүртэлх хугацаанд зөрчлийг арилгаагүй, зөрчлийн талаар хөндөгдөөгүй байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 24 дүгээр зүйлийн 24.4.2-т заасныг тус тус зөрчсөн байна.

3. Аман голын газарт археологи, палеонтологи, угсаатны зүйн судалгаа хийгээгүй байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 40<sup>1</sup> дүгээр зүйлийн 40<sup>1</sup>.2 дахь заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8 дахь заалтыг тус тус зөрчиж байна.
4. Баян-Өндөр сумын Засаг дарга ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулан Төрийн бус байгууллагын данс нээн мөнгө төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн байна.
5. Нутгийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулах гэрээний зохицуулалтыг нарийвчлан заагаагүйгээс тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нөлөөлөлд орох эрсдэлтэй байна.

### Гурав. Санал, дүгнэлт

#### *Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар:*

Ашигт малтмалын тухай хууль 66 зүйлтэй бөгөөд 49 зүйл буюу 74 хувь нь тусгай зөвшөөрөл олгох, сунгах, шилжүүлэх, цуцлах, барьцаалах болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүргийн талаарх харилцааг, 17 зүйл нь хуулийн зорилго, нэр томъёо, төрийн байгууллагын эрх, үүргийн зэргийг тодорхойлсон буюу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тухай хууль гэж үзэхээр болохоор буюу Монгол Улс өнөөдрийг хүртэл **уул, уурхайн тухай олон улсын жишиг болон бодит шаардлагыг хангасан хуульгүй** байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “”ашигт малтмал ашиглах” гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, **олборлох**, түүний ашигт агуулгыг **нэмэгдүүлэх, баяжуулах**, бүтээгдэхүүн **үйлдвэрлэх, борлуулах** болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг;” гэж тодорхойлсон байдаг. Сүүлийн жилүүдэд тусгай зөвшөөрөлгүй олон арван баяжуулах үйлдвэрүүд баригдан ашиглалтад орж, төмөр, хайлуур жонш, зэс зэрэг

ашигт малтмалын баяжмал экспортод гаргаж байгаа боловч тусгай зөвшөөрөл эзэмшигч биш, хүдэр олборлож байгаа аж ахуйн нэгж иргэд төлсөн учир давхардуулахгүй гэсэн шалтгаануудаар **ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөхгүй** байна.

Жишээлбэл: Дарханы төмөрлөгийн үйлдвэр жилд 1 сая тонн төмрийн хүдэр олборлож түүнийгээ тусгай зөвшөөлгүй аж ахуйн нэгжүүдэд 1 тонныг нь 30 000-60 000 төгрөгөөр борлуулж байгаа ба худалдаж авсан тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжүүд 1 тонныг нь 98-140 ам.доллараар экспортолж байна. Экспортолж байгаа аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрөл эзэмшигч биш бол **ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөхгүй** байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэр борлуулсан орлогоосоо 1 тэрбум гаруй төгрөгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлдөг бөгөөд экспортын үнийн дүнгээс тооцон төлбөл 15 тэрбум төгрөг төлөхөөр байгаа ба үүнээс улсад учирч байгаа хохирол 14 тэрбум орчим төгрөг болж байна. Мөн өнгөт чулуу, жонш экспортод их хэмжээгээр гаргаж байгаа ч **нөөц ашигласны төлбөр огт төлөхгүй** байна. Мөн шороон замаар тээвэрлэн **хөрсийг эвдрэлд оруулан** байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа ч ямар нэгэн төлбөр, нөхөн төлбөр төлөхгүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлд тогтоосон **хайгуулын зардлын доод хэмжээ хэт бага /га тутамд 0.5-10 ам.доллар/ байгаа нь санхүүгийн чадамжгүй этгээдүүдийн гар дээр тусгай зөвшөөрөл олноор төвлөрөх, тусгай зөвшөөрөл дамлан худалдаалах** нөхцөлийг бүрдүүлж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-д ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нь Монгол улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно гэж заасан. Гэтэл хуулийн 43.2-т тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү тохиолдолд хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө гэж заан **“туслан гүйцэтгэгч”-ийг хассанаас дээрх үүргээс чөлөөлөгдөн улс зохих нөхөн төлбөрөө авч чадахгүй хохирч буй хуулийн хийдэл** гарсан байна.

Монгол Улсын хэмжээнд хайгуулын болон ашиглалтын нийт 2759 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр олгогдсон байгаагаас хайгуулын 1390 /50.4 хувь/, ашиглалтын 1369 /49.6 хувь/ тусгай зөвшөөрөл байна. Гэвч түүнд тавих /Яамд, АМГ, МХЕГ, орон нутаг зэрэг/ хяналтын тогтолцоо сул байгаагаас зөрчил дутагдал газар авсан байна. Жишээлбэл: Дорноговь аймгийн Байгаль орчны албанаас 2014 оны 9 дүгээр сард хийсэн хяналт шалгалтаар Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй 21 уурхай ажиллаж байсныг илрүүлжээ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 19.1.3-т байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоор заасан байхад хугацаатай үүрэг өгсөн байна.

Ашигт малтмалын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг орон нутгийн иргэд

авч чадахгүй байгаагаас гадна тэдгээрийн эрх ашиг хуулиар огт хамгаалагдаагүй байна.

Тухайлбал: уурхайн эдэлбэр газарт орсон бэлчээр, усны нөхөн төлбөр, малчдын нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, орон нутгийн хөгжлийн талаар хэрхэн хамтарч ажиллах талаар эрх зүйн зохицуулалт байхгүйгээс орон нутагт авилга, ашиг сонирхлын зөрчил өсөх /дур зоргоор аливаа гэрээ байгуулах, хандив авах/, тэдгээрийн хоорондын зөрчил, маргаан нэмэгдэх хандлагатай байна. Ашигт малтмалын газраас хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход аймаг, нийслэлийн Засаг даргаас санал авдаг бөгөөд саналаа хугацаанд нь ирүүлээгүй нөхцөлд дэмжсэнд тооцож тусгай зөвшөөрлийг олгох зохицуулалттай байна. Мөн газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авахдаа АМГ-т бүртгүүлээгүй, шийдвэр нь алга болсон зөрчил их байгаагаас гадна уг шийдвэрийг гаргахдаа алдаа гаргаснаас шийдвэр нь хүчингүйд тооцогдох эрсдэлтэй 1738 орон нутгийн тусгай хэрэгцээний газар байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 48.1.1, 48.1.2, 48.6.3-д зааснаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуулын ажлын төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн хяналтын албанд, тайланг төрийн захиргааны байгууллагад хүргүүлэхээр зааснаас мэргэжлийн хяналтын байгууллага тайланд бүртгэлээр тавих хяналтаа алдаж, АМГ улсын байцаагчийн дүгнэлт гаргах боломжгүй тул хариуцлага тооцох чадавхигүй болж, энэ 2 байгууллагын ажлын уялдаа муугаас хуулийн хэрэгжилтэд тавих хяналт суларсан байна.

***Газрын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар:***

1. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан тусгай хэрэгцээний газрын ангилалд "бичил уурхайн зориулалтаар олгосон газар"-ыг нэмсэн нь Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг хязгаарлах, хориглох тусгай хэрэгцээний газрын зарим **заалтуудтай зөрчилдөж байгаагаас** улсын тусгай хамгаалалттай газарт бичил уурхайн нэрээр ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явагддаг болсон байна. /Жнь: Хэнтий аймгийн Норовлин сумын Тосон хулстайн байгалийн нөөц газарт/

2. Газрын тухай хуулийн 20.1.3-т зааснаар газрыг аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг тогтоох бүрэн эрхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ эдлэхээр заасан боловч улсын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан шийдвэр нь зөрчилтэй гэх 1738 газар байгаагаас тусгай хэрэгцээнд авах зорилго тодорхойгүй 374, шийдвэр гаргах эрхгүй байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргасан 545, тусгай хамгаалалтад авах хугацаа заагаагүй зөрчилтэй 819 шийдвэр байна.

3. Аймаг, сумын ИТХ дээрх шийдвэрээ хуульд заасны дагуу 30 хоногийн дотор АМГ-т хүргүүлэх үүргээ биелүүлдэггүй, орон нутгийн байгууллага, АМГ-ын мэдээлэл зөрүүтэй байдгаас тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээнд авсан газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл давхцуулах олгох, давхцуулан олгосон талаар хайгуулын үйл ажиллагааны явцад талуудын аль нь ч мэдээгүй байх зөрчлүүд гарч байна. /Баянхонгор

аймгийн Баян-Өндөр сумын Хүслэнтэйн аман голын нүүрсний уурхайн нөхцөл байдал/

4. Газар нутгийг улс, орон нутгийн тусгай хэрэгцээнд авахдаа хэт хязгаарлагдмал, /уулын зөвхөн оройн хэсгийг, булаг шандыг тойруулан хамгаалж байна/, ёс төдий хандаж байна. /Хутаг уул, Чандмань хар уул, Цагаан дэлийн агуй/

5. Газрыг тусгай хамгаалалтад авахдаа уулын зөвхөн оройн хэсгийг, булаг шандыг тойруулан хэт бага талбайгаар хамгаалж байгаа нь ёс төдий арга хэмжээ бөгөөд эко систем алдагдахад хүргэж байна.

6. Уурхай болон бусад барилга, дэд бүтцийн барилгын үйл ажиллагаанаас газарт орж байгаа айл, малчин өрхүүдийн эрх ашгийг хамгаасан журам заалт тодорхойгүй, өвөлжөө, хаваржаа, зуслангийн газрын үнэлгээ хийх аргачлал, журам байхгүй тул нөхөн олговор олгохгүй байх, олгосон ч сайн дурын үндсэн дээр ёс төдий буюу малчин өрхүүд нутаглах, малаа бэлчээх газаргүй болгох явдал түгээмэл гарч байна.

### **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн байдал**

Соёлын өв, дурсгалт газрыг судлах, зэрэглэл үнэлгээ тогтоох, хамгаалалтад авах талаар төв, орон нутгийн байгууллагын ажлын уялдаа холбоо сул, зохион байгуулалт учир дутагдалтай байгаагаас шалтгаалан соёлын өв устаж үгүй болох, дурсгалт газар унаган төрхөө алдаж дахин сэргээх боломжгүй болох зөрчил нийтлэг байна.

Нийт аймгийн Засаг дарга нарын үйл ажиллагаан дахь хуулийн хэрэгжилтийн байдлын үнэлгээгээр Соёлын өвийг хамгаалах тухай хууль хамгийн бага хэрэгжилттэй гарсан байна. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг бүх шатанд хангах, аймаг, нийслэлийн Засаг дарга нар харьяалах нутаг дэвсгэр дээрээ байгаа түүх, соёл, шинжлэх ухаан танин мэдэхүйн өндөр ач холбогдол бүхий дурсгалт газарт хамгаалалтын бүс тогтоох, Соёлын өвийн дурсгалт газар болгон хамгаалах талаар холбогдох санал боловсруулж Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах шаардлагатай.

Соёлын өвийг гэмтээсэн, устгасан, соёлын өвийн зүйлд хууль бусаар хайгуул, малтлага хийсэн үйлдэлд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, төрийн хяналтын механизмыг чангатган сайжруулах шаардлагатай байна.

### **Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийн байдал:**

БОНХЯ-наас ирүүлсэн тойм судалгаагаар уул уурхайн хайгуул, олборлолтын үйл ажиллагаагаар 19870.4 га газар эвдрэлд орсон байна. Харин Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулахыг хориглосон газарт байрлах нийт 138 аж ахуйн нэгжийн 242 тусгай зөвшөөрлийн талбайд учруулсан байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн сэргээлтийн

зардлыг 54.7 тэрбум төгрөг шаардагдана гэж тооцсон байна.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хуульд "үндэсний компани хийнэ" гэж зааснаас олон улсын стандартын дагуу бодитой нөлөөлөл тогтоох боломж нөхцөлийг хязгаарлаж байна. Мөн БОНУ-ний хүрээнд "нийгмийн нөлөөллийн" үнэлгээг бодитой хийх эрх зүйн орчин дутагдаж байна.

Байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх компани ажил зохион байгуулах, иргэд, ТББ нэхэмжлэх эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, улсад оруулсан нөхөн төлбөрийн орлогоос зардал, урамшууллыг олгох замаар төлбөр барагдуулах боломжийг судлах нь зүйтэй.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг иргэн, төрийн бус байгууллага, сум, дүүргийн Засаг дарга гаргахаар заасан бөгөөд хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах Засаг даргын үүрэг хангалтгүй байна. Тухайлбал, Дорноговь аймгийн Айраг сумын Засаг даргаас уул уурхайн нөхөн сэргээлт хийгээгүй асуудлаарх нэхэмжлэлийг шүүхэд гаргасан боловч нэхэмжлэлээсээ татгалзсан байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд гарч буй асуудлууд дээр үндэслэн **цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:**

- Хамгаалах шаардлагатай газар нутгийг экосистем, биологийн олон янз байдал, хөгжлийн хэтийн төлөвлөлттэй уялдуулан тодорхойлж **уул уурхайгаас ангид байх газруудыг бий болгох, бүс нутгийн экосистемийн үнэлгээ хийх** эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө тооцох эрх зүйн орчныг шинэчлэх, **тусгай санд урьдчилан байршуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх;**
- Ашигт малтмалыг олборлох, боловсруулахад **байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх** Европын холбооны стандартыг нутагшуулж мөрдүүлэх;
- Уул уурхайн үйл ажиллагааны **эрсдлийн сан бий болгож**, хариуцлагатай уул уурхайн зарчмыг бүх уул уурхайн үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- Ашигт малтмалыг олборлох, боловсруулах, тээвэрлэх, борлуулах зэрэг асуудлуудыг **иж бүрнээр** нь зохицуулах;
- Ашигт малтмал баяжуулах, борлуулах үйл ажиллагааг **тусгай зөвшөөрөлтэй явуулдаг болгох;**
- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтооход **хариуцах эзэн, хэрэгжих хугацааг** тодорхой тусгах;
- Гадаадын иргэдийг хуульд зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд **төлөх төлбөрийг туслан гүйцэтгэгч мөн адил төлдөг** болох;
- Хайгуулын ажлын нэгжийн өртөг тооцох арга, зарчмыг тодорхой болгох, **хайгуулын зардлын доод хэмжээг нэмэгдүүлэх**, нэг талбайд хийсэн ажлын

зардлыг буруу тооцсон буюу талбай хооронд шилжүүлэх, давхардуулах зөрчилд тусгай зөвшөөрлийг нь **цуцлах хүртэл хариуцлага** ногдуулдаг болох;

- Ашигт малтмалын болон бусад хуулийн хэрэгжихгүй байгаа заалтуудыг нэн даруй хэрэгжүүлж, уул уурхайн үйлдвэрлэлээс **улсын төсөвт орох орлогыг нэмэгдүүлэх** механизм бүрдүүлэх;
- Ашигт малтмалын тухай хуульд хайгуулын үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах үүргээ хэрэгжүүлээгүй болон зөрчил гаргасан бол, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байх зохицуулалтыг тусгах;
- Уурхайн хаалтын гэрээг олон улсын жишгээр /хаалтын ажлаас 5 жилийн өмнө байгуулдагаас үүргээс биелүүлэхээс зайлсхийдэг/ техник эдийн засгийн үндэслэлийг батлахаас өмнө байгуулдаг болох, техник эдийн засгийн үндэслэлийг батлахад байгаль орчны асуудал хариуцсан яамны саналыг харгалзан үздэг байх;
- Газрыг кадастрын бүртгэлд бүртгэх, хамгаалалтын бүс тогтоосон болон тусгай хамгаалалтад авсан газрыг улсын бүртгэлд бүртгэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалт, хариуцлагыг тодорхой болгох;
- Газрын тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуульд заасан тусгай хэрэгцээний газрын талаарх зүйл хоорондын зөрчлийг арилгах;
- хууль зөрчсөн болон хууль хэрэгжүүлэхгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог оновчтой бөгөөд тодорхой болгох;
- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сургалт явуулах, хуулийн хэрэгжилтийг хангах зааварчилгаа өгөх;
- Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан шийдвэрүүдийг АМГ-т бүртгүүлэх, тулгалт хийх, зөрчилтэй шийдвэрүүдийг залруулан нэг мөр болгон цэгцлэх арга хэмжээг орон даяар авч хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээний газрын нэгдсэн мэдээллийн сан бий болгох, холбогдох байгууллагуудад нэвтрүүлэх шаардлагатай байна;
- Газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авахдаа цогц байдлаар хандах.

• **Иргэдийн өргөдлийн дагуу хяналт шалгалтад хамрагдсан газруудын асуудлыг шуурхай шийдвэрлэх талаар дараах чиглэлийг Засгийн газарт өгөх саналтай байна. Үүнд:**

#### 1. Цагаан дэлийн агуйн талаар:

- Цагаан дэлийн агуйг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтад авах хэрэгцээ, шаардлагыг судлан шаардлагатай бол Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх;
- Байгаль орчинд учирсан хохирлыг тооцож буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авах;
- Уул, уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас эрх ашиг нь хөндөгдөж хохирсон иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх.

## 2. Хутаг уулын талаар:

- Хутаг уулыг орчны байгаль түүхийн дурсгалт газруудын хүрээнд цогцоор нь улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг судлан Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх;
- Ашигт малтмалын тухай хуулийн 40<sup>1</sup>.2-д “Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно” гэж заасныг зөрчиж, угсаатны зүйн мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгээгүй олгосон ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.

## 3. Чандмань хар уулын талаар:

- Чандмань хар уулын тусгай хамгаалалтад авсан талбайн хэмжээг өргөжүүлэн шийдвэрлэх;
- Ашигт малтмалын тухай хуулийн 3.2, 4.1.23, 11.1.13, 11.1.23 дахь хэсгийг, Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг бүхэлд нь зөрчсөн Дэлгэрэх сумын ИТХ-ын тогтоолыг хүчингүй болгох чиглэлийг өгөх, бичил уурхайн үйл ажиллагааг зогсоох;
- Хууль бус шийдвэр гаргасан, хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа зохион байгуулсан, хууль бусаар орлого олсон Дэлгэрэх сумын нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох.

## 4. Аман голын талаар:

- Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших Аман гол нэртэй газарт явуулсан ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах, хариуцлага тооцох, орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах талаар шуурхай арга хэмжээ авч тус Байнгын хороонд танилцуулах.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ АЖЛЫН ХЭСЭГ

--oOo---